


ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ХАНДАЛТ



№	Өргөдөл, гомдлын агуулга	Тоо		Хувь		Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ /2026 оны 1-р улирал/
		2025 оны I	2026 оны I	2025 оны I	2026 оны I	
1	Эмч эмнэлгийн ажилтны харьцаа, хандлага	5	3	29.41%	20%	Харилцааны сэтгэл зүйч Г.Алтанцоож Ph.D-ийг урьж “Хамт олны үнэ цэнэ, харилцаа түүний мөн чанар” сэдвийн хүрээнд БОЭТ-ийн 104 эмчийг хамруулсан сургалтыг Ёс зүйн хорооноос зохион байгуулан ажиллав. Мөн шинээр ажилд орсон ажилтнуудад эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээний сургалтыг тогтмол зохион байгуулж, тайлант оны эхний улирлын байдлаар нийт 12 ажилтныг хамруулсан.
2	Эмнэлгийн тусламж үйлчилгээнд сэтгэл ханамжгүй	4	3	23.52%	20%	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн үйлчлүүлэгчид зөвөлгөө өгөх ур чадварыг сайжруулах, оношилгоо, эмчилгээний талаарх мэдээллийг энгийн ойлгомжтой үг хэллэгээр тайлбарлах талаас нь холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.
3	Эмнэлгийн зохион байгуулалт, дотоод орчны тохижилтыг сайжруулах	3	1	17.64%	6.6%	Тус төвийн барилга байгууламж нь 1986 онд ашиглалтад орсон бөгөөд тухайн үед суурилуулсан цахилгаан шатны тоног төхөөрөмжүүд нь цаг хугацааны явцад элэгдэж, эвдрэл гэмтэл тогтмол үүсэх болсон. Амбулаторийн хэсгийн цахилгаан шат нь энэ оны эхнээс эвдрэл гарч түр хугацаанд ажиллагааг зогсоосон бөгөөд шаардлагатай засвар, үйлчилгээний ажлыг хийж хэвийн ажиллагаанд оруулсан. 2025 оны 10 дугаар сараас эхлэн уг цахилгаан

						шатанд дахин эвдрэл гарч, засварт шаардлагатай, тохирох сэлбэг материал олдохгүй байгаа тул бүрэн засварлах боломжгүй нөхцөл үүссэн байна. Цаашид цахилгаан шатны найдвартай үйл ажиллагааг хангах, шаардлагатай сэлбэг материалын асуудлыг шийдвэрлэх боломжийг судлан ажиллаж байна.
4	Эмнэлгийн тоног төхөөрөмжийг сайжруулах	2	0	11.76%	0%	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх чиглэлээр 2025 онд 3,392,060,445 төгрөгний үнэ бүхий 144ш тоног төхөөрөмжөөр хангагдсан ба өмнөх онтой харьцуулахад 0.5 хувиар нэмэгдсэн буюу 96%ийн хангалттай байна.
5	Талархал	3	7	17.64%	46.66%	Эмч эмнэлгийн мэргэжилтний харьцаа хандлага, мэргэжлийн ур чадваруудыг нэмэгдүүлэх сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байгаатай холбоотой иргэд, үйлчлүүлэгч нараас ирэх талархлын тоо өссөн байна.
6	Бусад	0	1	0%	6	